

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2021 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ
ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ 3 ДУГААР САРЫН 30-НЫ ӨДӨР
/МЯГМАР ГАРАГ/-ИЙН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН
ТОВЬЁГ**

№	Хэлэлцсэн асуудал	Хуудасны дугаар
1.	Хуралдааны товч тэмдэглэл:	1-6
2.	Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	7-55
	1. “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл /Шүүхийн ерөнхий зөвлөлийн болон Шүүхийн сахилгын хорооны гишүүн бус гишүүнийг сонгон шалгаруулах үүрэг бүхий/	8-15
	2. Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар 2020.05.07-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/	15-28
	3. Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/	28-33
	4. Сogтyуpуулaх ундaаны эргэлтэд хяналт тавих, архидан cогтyуpахтай тэмцэх тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2021.03.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	33-55

**Монгол Улсын Их Хурлын 2021 оны хаврын ээлжит чуулганы
Хууль зүйн байнгын хорооны 3 дугаар сарын 30-ны өдөр
/Мягмар гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Хууль зүйн байнгын хорооны дарга С.Бямбацогт ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын нөхцөл байдалтай холбогдуулан Засгийн газраас Гамшгаас хамгаалах тухай хуулийн дагуу өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн тул Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 6 дугаар зүйлд зааснаар Байнгын хорооны хуралдааныг цахим хэлбэрт шилжүүлж, Хууль зүйн байнгын хорооны дарга С.Бямбацогт, Улсын Их Хурлын гишүүн Ш.Адъяаа, Н.Алтанхуяг, Ц.Мөнхцэцэг, Х.Нямбаатар, Б.Пүрэвдорж, Ш.Раднаасэд, Ж.Сүхбаатар, Д.Цогтбаатар нар Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимаас, бусад гишүүд MyParliament программ болон цахим хуралдааны программыг ашиглан Байнгын хорооны хуралдаанд цахимаар оролцов.

Хуралдаанд ирвэл зохих 19 гишүүнээс 15 гишүүн цахим хуралдааны программын ирцэд бүртгүүлж, 78.9 хувийн ирцтэйгээр хуралдаан 14 цаг 12 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Эмнэлгийн чөлөөтэй: Н.Учрал.

Хураангуй тэмдэглэл

Хоёр.Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар 2020.05.07-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн бөгөөд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ж.Хунан, Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн Б.Энхболд нар “Их эзэн Чингис хаан” танхимаас оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Эрх зүйн дүн шинжилгээний хэлтсийн ахлах зөвлөх Г.Золжаргал, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх М.Үнэнбат, референт Л.Мөнхчимэг, Хяналт шалгалт,

үнэлгээний газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн референт Б.Галсанбат нар байлцав.

Хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай ажлын хэсгийн танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэг “Их эзэн Чингис хаан” танхимаас танилцуулав.

Ажлын хэсгийн танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар, Н.Алтанхуяг, Д.Ганбат, Б.Энхбаяр, Х.Нямбаатар, Ж.Сүхбаатар нарын тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэг хариулж, тайлбар хийв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.12-т заасны дагуу Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн талаар ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалтыг гар өргөж явуулав.

Нэг.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42.2.1-д заасны дагуу хураалгах санал:

С.Бямбацогт: 1.Төслийн 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалтын “арга” гэсний дараа “хэрэглэж” гэж нэмж, мөн зүйлийн 7.1.2 дахь заалтын “алдар хүнд, нэр төрийг” гэснийг “үйл ажиллагааг” гэж өөрчилж, 7.1.3 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“7.1.3.хүний эрх, эрх чөлөө, бусдын нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаах.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 1
Бүгд: 12
91.7 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Төслийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“13.1.Энэ хуулийг 2021 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 3
Бүгд: 12
75.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.12-т заасны дагуу Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалтыг гар өргөж явуулав.

**Хоёр.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай
хуулийн 42.2.3-т заасны дагуу хураалгах санал:**

С.Бямбацогт: 1.Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“Хүний эрх хамгаалагч нь хүчирхийллийн арга хэрэглэж, тайван бус аргаар үйл ажиллагаа явуулсан, явуулахыг уриалсан, хүний эрх хамгаалагчийн үйл ажиллагааг хувийн ашиг сонирхолд ашигласан, хүний эрх, эрх чөлөөг зөрчиж, бусдын нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 2
Бүгд: 12
83.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хурааж дууслаа.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 15 цаг 10 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн бөгөөд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ж.Хунан, Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн Б.Энхболд нар “Их эзэн Чингис хаан” танхимаас оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Эрх зүйн дүн шинжилгээний хэлтсийн ахлах зөвлөх Г.Золжаргал, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх М.Үнэнбат, референт Л.Мөнхчимэг, Хяналт шалгалт, үнэлгээний газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн референт Б.Галсанбат нар байлцав.

Хуулийн төслүүдийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаар ажлын хэсгийн санал, дүгнэлтийг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэг “Их эзэн Чингис хаан” танхимаас танилцуулав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Монгол Улсын Хүний эрхийн

Дэлгэрэнгүй тэмдэглэл

***Хоёр.Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай
хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд
Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар 2020.05.07-ны өдөр өргөн
мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/***

Хоёрдугаар асуудалдаа оръё.

Хүний эрх, хамгаалагч эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулъя.

Эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгийн танилцуулга болон эцсийн хувилбарын төслийг гишүүдэд тараасан байгаа.

Хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай ажлын хэсгийн танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Цэрэнжамцын Мөнхцэцэг танилцуулна.

Ц.Мөнхцэцэг: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурал 2021 оны 3 дугаар сарын 25-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг 2021 оны 3 дугаар сарын 25-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаан явуулах үед хуралдаан даргалагчаас өгсөн чиглэлийн дагуу ажлын хэсэг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1-д заасны дагуу холбогдох зарчмын зөрүүтэй саналуудыг боловсруулан танилцуулж байна.

Тодруулбал, хуулийн дагаж мөрдөх хугацааг 2021 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс байхаар, Хүний эрх хамгаалагчид хориглох үйл ажиллагааны зарим зохицуулалтыг хууль санаачлагчдын өргөн мэдүүлсэн төслөөр нь үлдээх талаар тус тус санал гаргаж байна.

Түүнчлэн Хүний эрх хамгаалагч эрх зүйн байдлын тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар хуулийн төсөл хоорондын зөрчлийг арилгах шаардлага гарсан тул Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3-т заасны дагуу Байнгын хорооны хуралдаанаар дахин санал хуруулах нь зүйтэй гэж үзлээ.

Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөлд Хүний эрхийн Үндэсний Комиссын хүний эрх хамгаалагчийн асуудал эрхэлсэн гишүүн Хүний эрх хамгаалагчийн хорооны дарга байх тухай ажлын хэсгээс гаргасан саналыг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар дэмжсэн тул хууль хоорондын уялдааг хангаж, зөрчлийг арилгах зорилгоор Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд заасны дагуу Та бүхэнд тараасан байгаа.

Ажлын хэсгийн хуралдаанаар хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэх үед Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 2 дугаар зүйлд заасан Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүний тоог зургаа болгон нэмэх зохицуулалтын талаар эсрэг байр суурьтай

байгаагаа илэрхийлэн ажлын хэсгийг нь танилцуулгад тусгуулахаа илэрхийллээ.

Түүнчлэн төслийн агуулга, зарчмыг алдагдуулахгүйгээр үг хэллэг, дэс дараалал, бүтцийн шинжтэй засварыг хийж, нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналуудыг төсөлд нэмж тусган эцсийн хуулбарын төслийг бэлтгэж Та бүхэнд тараасан байгаа.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Байнгын хорооны эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгээс гаргасан танилцуулга болон зарчмын зөрүүтэй саналыг эцэслэн хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

С.Бямбацогт: Ц.Мөнхцэцэг гишүүнд баярлалаа.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя.

Ажлын хэсгийн гишүүн Жаргалсайханы Хунан Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн, комиссын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч, Батзэвэгийг Энхболд Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн цахимаар оролцож байгаа.

Танилцуулгатай холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Ажлын хэсгээс. Ц.Мөнхцэцэг гишүүн. Д.Цогтбаатар гишүүн. Х.Нямбаатар гишүүн кнопоо дарчих. Х.Нямбаатар гишүүнээр тасаллаа. Д.Цогтбаатар гишүүн асуултаа асууя.

Д.Цогтбаатар: Гишүүддээ өдрийн мэндийг хүргэе.

Би зүгээр их товчхон нэг юу асуух гэсэн юм. Энэ хуулийг санаачлахад хамгийн гол үүнийг санаачилж оруулж ирж байгаа хүмүүс чинь манай хүний эрхийн төрийн бус байгууллагууд, яг газар дээрээ ажиллаж байгаа хүмүүс байгаа. Тэгээд тэр хүмүүс маань ганц хоёр юм, саналууд тавьж байгаа. Үүнийг нь би бас чуулганы нэгдсэн хуралдаан дээр хэлсэн.

Тэгэхлээр Ц.Мөнхцэцэг гишүүн ээ, нөгөө 7.2.1. Тийм ээ. Энэ дээр юуг зааж өгсөн байсан. Нөгөө хориглох зүйлийг. Тэгээд энэ дээр хууль санаачлагчийн гаргасан.

Ер нь хүний эрхийн байгууллагууд тэр саналыг, томъёоллыг нь зарчмын хувьд дэмжиж байгаа. Гэхдээ хэтэрхий нарийсгасан байна. Анхны тэр

саналаараа нэлээн өргөн санаатай орж ирсэн гэсэн байсан. Тэр дээр ямар ажлын хэсэг дээр байр суурьтай байгаа бол? Би үүнийг л тодруулах гэсэн юм.

Тэгээд бусад юун дээр би явцын дунд өөр өөрийнхөө саналыг хууль санаачлагчийн хувьд хэлээд явъя. Баярлалаа.

С.Бямбацогт: Ц.Мөнхцэцэг гишүүн хариулах уу?

Ц.Мөнхцэцэг: Тэгэхээр хүний эрх хамгаалагчийн үйл ажиллагаанд хориглох зүйл гэдгийг ажлын хэсэг дээр нэмж яриад, мөн олон улсын судалгаа болон бусад Монгол Улсын Зөрчлийн тухай хууль, зохицуулалтуудыг үзээд нөгөө террорист буюу хүчирхийллийн замаар, тайван бус аргаар тэмцэл явахыг хориглосон байгаа.

Энэ явцад хуулийн этгээд болон хувь хүний ажил хэргийн нэр хүндийг гутаах гэдэг. Хориглосон байсан юм. Тэгээд манай иргэний нийгмийн байгууллагууд болон хүний эрхийн тэмцэгчид маань маш олон удаагийн тохиолдлоор орон нутагт байгаль орчноо хамгаалах гэдэг юм уу, уул уурхайн компаниудтай хийсэн тэмцлийн явцад. Хэрвээ энэ заалт орох юм бол одоо хүний эрх хамгаалагчийн үйл ажиллагаа маань хязгаарлагдах гээд байна.

Бид шүүхээр тогтоолгох хүртэл нь хүний эрхийн үйл ажиллагаа маань тодорхой этгээдийн гэдэг юм уу, тодорхой хүмүүсийн хувьд эрх ашиг нь зөрчсөн үйл мэтээр харагдах магадлалтай байдаг.

Тийм учраас олон улсын загвар хуулийнхаа дагуу хүний эрх хамгаалагчийн үйл ажиллагааг харьцангуй бас өргөн хүрээндээ гэдэг юм уу, олон улсын жишгийн дагуу оруулж өгөөч ээ гэсэн байгаа.

Тийм учраас ажлын хэсэг дээр 4 удаагийн хуралдааныхаа дараа бид “хүний эрх чөлөөг зөрчихгүй байх” гэдэг агуулгаар буюу тухайн хуулийн өргөн барьсан анхны төслийнх нь дагуу найруулга явсан байгаа.

С.Бямбацогт: Энэ биш ээ. Тийм. Хуралдаан даргалагчаас ийм чиглэл өгөөгүй.

Тэгээд яасан. Хүний эрх хамгаалагчийн нэрийн доор бусдын нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутааж болно гэж орох гэж байна шүү дээ. Тийм үү. Тийм болохоор ийм байж болохгүй.

Тодруулаад хэл. Хариулт өгье.

Ц.Мөнхцэцэг: Энэ дээр хүний эрх хамгаалагч маань Монгол Улсад үйлчилж байгаа хууль тогтоомжууд, мөн олон улсын хүний эрхийн гэрээ конвенц дагах ёстой.

Тэр утгаараа хүний нэр төр, алдар хүнд, хүний хууль ёсны нууц гэдгийг хуулийн дагуу зөрчихгүй байх үүрэгтэй. Энэ маань тусгайлан энэ заалтаар биш, энэ хуулийн маань бүхэлдээ агуулгаар буюу агуулгад хууль тогтоомжийн

дагуу хүчирхийллийн бус аргаар үйл ажиллагаа явуулна гэдэгтээ орж явсан гэдэг утгаар тэр үгийг хассан байгаа.

Өөрөөр хэлбэл хүний эрх хамгаалагч бол хуулийн дагуу үйл ажиллагаа явуулна. Энэ дотор чинь хүний нэр төр, алдар хүнд. Тэгээд бусад хувийн нууц бүгд орж байгаа шүү.

С.Бямбацогт: Наадах чинь хангалттай биш байна шүү. Тэгж худлаа тайлбар хийхгүй шүү.

Н.Алтанхуяг гишүүн асуултаа асууя.

Н.Алтанхуяг: Хэдүүлээ ажил хийдэг л юм хийхгүй бол. Энэ байгууллага байгуулсаар байгаад л бид балрах юм шиг байна даа.

Долоон хүнтэй юм ингээд нэмээд байгуулаад. Одоо үүнийг л байгуулаад өгвөл хүний эрх гэдэг юмыг алаад өгнө л гэж хэлж байх шиг байна. Энэ чинь бас л үлгэр л дээ.

Ер нь паркенсоны хуулиар орон тоо нэмэгдэхийн хэрээр юм чинь дампуурдаг юм. Тэгээд та нар дахиад нэг асуудал үүслээ. Энэ хар аа. Энэ одоо хэн нь нэмчих вэ?

Одоо энэ ингээд Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хууль гээд оруулж ирэнгүүтээ хойноос нь нөгөө нэг Үндсэн хуулиа өөрчилж байна. Хүний эрхийн Үндэсний Комиссын хуульд өөрчлөлт оруулаад.

Одоо нөгөө таван гишүүн, дарга арай хийж бий болгож авсан чинь одоо хүч нь хүрэхгүй зургаа болгоё гээд солиороод байх юм. Үгүй ээ, энэ нэг орон тоогоор хөөцөлдсөн, нэг баахан дарга нар бий болгосон юмаа боливол яасан юм.

Энэ одоо хаанаас гараад ирсэн юм? Хэн хариулах юм бол? Ц.Мөнхцэцэг гишүүн хариулах юм болов уу? Хэн нь хариулах юм? Энэ яагаад орон тоо нэмж байгаа юм?

Таван хүнтэй ажиллаад. Баахан юм болж болж бид хэдэн хүн сонгоод биз дээ. Одоо та нар энэ хууль гаргаад долоон хүн бий болгож байгаа юм.

Дахиад энэ хуулиа гаргангуутаа хулгайгаар дахиад энд нь таван хүний зургаа болгож байгаа юм. Ийм юм байж болохгүй шүү дээ. Хэн хийсэн юм, үүнийг.

С.Бямбацогт: Хариулъя. Ц.Мөнхцэцэг гишүүн. Ажлын хэсгийн ахлагч.

Ц.Мөнхцэцэг: Тэгэхээр Н.Алтанхуяг гишүүний асуултад хариулъя.

Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хууль бол Монгол Улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа хүний эрх хамгаалагчдын эрх зүйн хамгаалалтыг бий болгох буюу Нэгдсэн Үндэстний Байгууллагын

конвенцын дагуу олон улсын хүний эрхийн нэг шинэ механизм орж ирж байгаа юм.

Энэ утгаараа Хүний эрхийн Үндэсний Комиссын нэг гишүүн буюу хүний эрх хамгаалагчийн асуудал хариуцсан гишүүн бол хүний эрхийн чиглэлээр үйлчилгээ явуулж байгаа тухайн үйл ажиллагааг хариуцна гэсэн үг.

Өөрөөр хэлбэл Хүний эрхийн Үндэсний Комиссын одоо байгаа таван гишүүнээс ажил үүргийн хувьд арай өөр буюу шинэ хүний эрхийн механизмыг хариуцаж байгаа.

Хоёрдугаарт нь, олон улсын загвар хууль болон бусад хуультай уялдуулахад хүний эрх хамгаалагчийн үйл ажиллагаа маш өргөн хүрээтэй байгаа.

Энэ үйл ажиллагаанд Хүний эрхийн Үндэсний Комиссын одоо байгаа үйл ажиллагаа, механизмууд. Тэгээд дээрээс нь шинэ заалтуудаар хүний эрх хамгаалагчийн эрсдэл, учирсан хохирол гэдэг юм уу, хүний эрх хамгаалагчийн үйл ажиллагаанд үзүүлэх төрийн дэмжлэгүүдийг хариуцсан тодорхой бүтэц байхаас өөр аргагүй болсон байгаа.

Тэгээд дээрээс нь нэмж хэлэхэд Хүний эрхийн Үндэсний Комисс маань хүний эрх хамгаалагч гэсэн шинэ үүрэг бүхий гишүүнтэй болохоос гадна энэ гишүүн байнгын буюу зургаан жилийн хугацаатай тухайн хүний эрхийн хороогоо ахлаад явахгүй.

Хүний эрхийн комиссын гишүүд маань зургаан жил ээлжлээд, нэг нэг жилээр ээлжлээд явах зохицуулалт орж байгаа. Өөрөөр хэлбэл Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс дээр хүний эрх хамгаалагчийг хамгаалах тухай шинэ үүрэг, функц орж байгаа учраас энэ гишүүн ингээд шинээр нэмэгдэж орж ирж байгаа юм.

С.Бямбацогт: Д.Ганбат гишүүн асуулт асууя.

Д.Ганбат: Хүний эрхийн асуудал манай Монгол Улсад үнэхээр хэцүү байгаа шүү дээ. Энэ талаар хууль санаачлаад явж байгаа гишүүдээ дэмжиж байна. Энэ хуулийг ярилцаад сайжруулаад явах ёстой байх.

Та хэд маань бас тэр Хууль зүйн яаман дээр оччихсон баахан бичиг өргөөд л хүний эрхийг хамгаалаад яваад байна уу, яаж яваад байна. Тийм ээ. Ямар учир начиртай юм хийгээд байна. Эсвэл энэ хуулиар яриад байгаа юм уу?

Тухайлбал, прокурорын байгууллага хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавьж шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцоно гэж байгаа.

Энэ хүний эрхийг төрийн өмнөөс хамгийн сайн хамгаалах байгууллага энэ шүү дээ. Энэ маань өнөөдөр ямар болчихоод байна?

Одоо өнөөдрийн сонин дээр гэхэд л энэ албан тушаалаа ашиглаж хөрөнгө дээрэмддэг прокурорууд хариуцлага тооцох уу л гэж байна. Иймэрхүү нөхцөл байдалд яаж оролцож байна. Наад хуулиар чинь бол. Тийм зүйл, заалт байгаа юу?

Одоо энэ хоёр гурван прокурор тэр ажил төрлийг нь хойшлуулаад яачих шиг боллоо. Тэр хүмүүстэй хариуцлага ярьдаг, барьдаг ийм юм байна уу, байхгүй юу?

Одоо юу гэнэ вэ. Максимын Чинбат, Сүхбаатар дүүргийн прокурор н.Энхтөрч гэнэ үү. Ийм хүмүүс анги бүлгээрээ нийлээд хуйвалдаад хүний хөрөнгийг дээрэмддэг гээд сонин хэвлэл дээр гарчихсан байна. Төрийн ордны хажуугаар баахан хүний эрх шаардсан, хууль хүчний байгууллагуудаас нэхсэн ийм хүмүүс гороолж байна, жагсаж байна, шатаж байна. Олон давхар байшингаас унаж байна. Энэ нөхцөлд яаж ажиллаад, яах гээд байна вэ?

Нөгөө талаар эд нар чинь бүр ангиараа, байгууллагаараа ингэж ажилладаг болсон байна. Прокурорууд нь нэг жилийн төгсөлт байдаг бол түүгээрээ хоорондоо ял наймаалцдаг прокурорын хонгил гэж бий болгосон. Нөгөө шүүхийн хонгилыг яриад байхад хажуугаар нь бас прокурорын хонгил бий болгочихсон байна шүү.

Энэ юм дээрээ наад хүний эрхийг хамгаалах энэ юм чинь одоо яг.../минут дуусав/

С.Бямбацогт: Ц.Мөнхцэцэг гишүүн хариулъя.

Ц.Мөнхцэцэг: Тэгэхээр Д.Ганбат гишүүний хөндөж байгаа өнөөгийн Монгол Улс дахь хүний эрхийн зөрчил үнэхээр бодитой байгаа.

Хүний эрхийн зөрчил, эрүүдэн шүүсэн зөрчлүүдээс авхуулаад, ноцтой зөрчлөөс авхуулаад уул уурхай, газар, байгаль орчин, тэгээд нутаг бэлчээрээ хамгаалах гэсэн иргэдийн тэмцэл, хөдөлгөөн асар их байдаг юм байна.

Түүний төлөө дуугарч тэмцсэн хүмүүс их хэлмэгддэг. Амь нас, эрүүл мэндэд нь халддаг.

Тэгэхээр иймэрхүү ноцтой байгаа учраас олон улсын жишгээр Монгол Улсад хүний эрхийг хамгаалахын төлөө зүтгэж явж байгаа хүмүүстээ төрийн дэмжлэг үзүүлэх, үйл ажиллагаанд нь хамгаалал гаргах зохицуулалтаар энэ хуулийг оруулж ирсэн байгаа.

Мөн хүний эрхийн зөрчил хамгийн их гарч байгаа зүйл бол шүүх шатанд, цагдаагийн эрэн сурвалжлах, мөрдөн байцаах шатанд маш их гарч байна.

Тэгээд маш олон хүний эрхийн зөрчил гаргасан этгээдүүд учруулсан нөхөн хохирлоо төлөхгүй байна. Маш олон иргэд, хувиараа тэмцэж байгаа хүмүүс, зарим тохиолдолд иргэдийн эвлэлдэн нэгдсэн хөдөлгөөнүүд хүртэл зөрчигдсөн эрхээ сэргээлгэхийн төлөө маш их тэмцэж байна.

Энэ дээр манай Хүний эрхийн дэд хорооны гишүүний хувьд бас миний бие сүүлийн хэдэн сар үнэхээр энэ асуудлыг бодитой хараад тодорхой хуулиудад өөрчлөх шаардлагатай нэлээд олон асуудал байна.

Тийм учраас прокурор, шүүхтэй холбоотой энэ асуудлууд бол бас маш олон зөрчил гарч байгаа. Тийм учраас шүүх шатанд томилгоо бол улс төрөөс хараат бус байх ёстой.

Дээрээс нь хүний эрх хамгаалагчдадаа төрийн дэмжлэг, төрийн албан хаагчид дэмжлэг үзүүлэх ёстой. Тэгэхээр иймэрхүү тодорхой заалтууд энэ дээр орж байгаа.

Тэгээд ялангуяа хүний эрх зөрчигдөх хамгийн их магадлалтай буюу хууль сахиулах байгууллагынхны дунд хүний эрхийн чиглэлээр соён гэгээрүүлэх, хүний эрх хамгаалагчийн тухай сурталчилгаа, мэдээллийн ажлуудыг хийхээр хуульд заасан байгаа.

С.Бямбацогт: Б.Энхбаяр гишүүн асуултаа асууя.

Б.Энхбаяр: Надад нэг л асуулт байгаа юм. Тэгэхээр Хүний эрх хамгаалагчийн хуулийг дэмжиж байгаа. Энэ бол иргэн бүрийн, хүн болгон хүний эрхийн хамгаалагч байх үзэл санаатай.

Тэгээд энэ хуулийг дагалдуулаад Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүний одоо байгаа таван гишүүний тоог зургаа болгох гэж байгааг бол дэмжихгүй байгаа. Үндэслэл тодорхойгүй байна.

Хүний эрхийн Үндэсний Комиссыг бид хуулийг шинэчилж батлаад гурван гишүүнтэй байсныг нь үндсэн орон тооны тав, дээр нь нэмэх нь эрүүдэн шүүхийн тусгай комиссар гээд үндсэндээ зургаан гишүүнтэй болгосон. Орон тоог нь хоёр дахин нэмсэн. Хуучнаас нь.

Одоо дахиад зургаа багадаад байна. Долоо болгоё гэдэг санал бол би энэ “тоон дотор нөгөө үсэг цохиж явна” гэдэг шиг, “гуя дагаж хүзүү” гэдэг шиг үндэслэл биш гэж харж байгаа.

Одоо ажиллаж байгаа Хүний эрхийн Үндэсний Комиссын таван гишүүний нэг нь хүний эрх хамгаалагчдынхаа хороогоо ахлаад явах бүрэн боломжтой. Яагаад гэхээр энэ хороо чинь өөрөө угаасаа орон тооны бус.

Тэгээд угаасаа Хүний эрхийн Үндэсний Комисс чинь нийт иргэдийнхээ л хүний эрхийн асуудлыг л хамгаалах гэж л байгуулагдсан. Үндсэн чиг үүрэг нь ч гэсэн ийм байгаа.

Тэгээд бид тоо нэмэхээр ажил сайжирна. Одоо энэ таван гишүүн нь хүний эрхийг хамгаалахгүй ч байгаа ч юм шиг нэг мессеж өгөөд л. Эсвэл нөгөө хүндээ байгаад байгаа юм уу. Болж бүтэхгүй хүмүүс байгаа бол чөлөөлчхөж болно шүү дээ.

С.Бямбацогт: Ц.Мөнхцэцэг гишүүн хариулъя. Ажлын хэсгийн ахлагч.

Ц.Мөнхцэцэг: Тэгэхээр Хүний эрхийн Үндэсний Комисс, тэгээд Хүний эрх хамгаалагчийн тухай хуулийн үзэл баримтлалыг судлах ажлын хэсгийг ахлах явцад бид нэлээд олон удаагийн хүний эрх зөрчсөн кэйсүүд. Мөн нэлээд олон удаагийн хурал, уулзалтууд. Иргэний нийгмийн байгууллагууд. Тэгээд эрүүдэн шүүхийн асуудлаар гэх мэтийн тусгайлсан хэд хэдэн хэлэлцүүлэг, уулзалтууд хийсэн байгаа.

Энэ явцад өнөө үйлчилж байгаа манай Хүний эрхийн Үндэсний Комиссын механизм өмнөх үеийг бодоход шинэ хуулиараа харьцангуй нөхцөл байдал дээрдсэн боловч шиг бас яах аргагүй улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулах. Тэр байтугай Монгол Улсын хилийн гадна нутаг дэвсгэрт гадаад улс оронд хүний эрх зөрчсөн тохиолдлуудад хүрч ажиллах боломж хомс юм байна. Манай комиссын механизм, комиссын орон тоо болон бусад санхүүжилт гээд энэ болгон дээр нэгдүгээрт дүгнэлт хийсэн.

Хоёрдугаарт нь, энэ оруулж ирж байгаа хүний эрх хамгаалагчийн эрх зүйн зохицуулалт гээд олон улсын энэ шинэ механизм Монгол Улсын ойрын хэдэн жилд үнэхээр чухал механизм байна.

Шилжилтийн 30 жилийн явцад гэдэг гэдэг юм уу, түүний дараах нөхцөл байдалд маш олон салбар, олон хууль тогтоомжууд, хөдөө аж ахуй, уул уурхай гээд олон салбарт хүний эрхийн зөрчил түгээмэл байгаа.

Тийм учраас энэ асуудлыг тусгайлан хариуцсан орон тооны ийм хараат бус байгууллага, хараат бус комисс, гишүүн ажиллахаас өөр арга байхгүй байгаа.

Тийм учраас өдгөө үйлчилж байгаа Хүний эрхийн Үндэсний Комиссыг нэгдүгээрт чадавхжуулах.

Хоёрдугаарт, шинэ үүрэг, функцийг нь хариуцуулсан гишүүн шинээр оруулах яах аргагүй ийм үндэслэл байгаа учраас энэ хууль дээр маань ингээд явж байгаа.

Тэгээд Хүний эрх хамгаалагчийн хороо нэлээд өргөн үйл ажиллагаа явуулна. Хүний эрх хамгаалагчийн эрх зөрчигдсөн тухай асуудлаар гомдол, мэдээлэл хүлээж авна. Хэрэгцээ шаардлага, эрсдэлийг үнэлнэ. Дүгнэлт явуулна.

Тэгээд яг тухайн аймаг, орон нутаг руу хүрч ажиллана. Яаралтай болон бас ноцтой байдал нэлээд үүсдэг юм байна.../минут дуусав/

С.Бямбацогт: Х.Нямбаатар гишүүн асуулт асууя.

Х.Нямбаатар: Баярлалаа. Би Х.Мөнхцэцэг гишүүнээс маш тодорхой хоёр гуравхан асуулт асууя.

Д.Цогтбаатар гишүүн хууль санаачлагчийн хувьд бас хариулж болох болов уу? Дэгийн тухай хуулиар.

Энэ Хүний эрх хамгаалагчийн хууль, хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдал нь шүгэл хүлээгчээс яг юугаараа их ялгагдаж байгаа юм? Энэ дээр нэг хариулт өгөөч.

Хоёрдугаарт, хуулийн 4 дүгээр зүйлд заасан хүний эрх хамгаалагчийн талаар энэ хуулийн нэр томъёог тодотгож өгсөн байна л даа. Тэгээд энэ дээр хэт ерөнхий тодорхойлсон юм биш үү? Өөрөөр хэлэх юм бол зарим тохиолдолд нам, улс төрийн зорилго, агуулгаар өөрсдийгөө хүний эрх хамгаалагч гэдэг статусаар, хүний эрхийг хамгаалагчийн байр суурин дээр янз бүрийн байдлаар улс төрийн тоглолт хийх нөхцөл байдлыг үүсгэх вий гэдэг болгоомжлол байна.

Гуравдугаарт, хүний эрх өөрөө их өргөн хүрээтэй ойлголт. Бид зөвхөн эрүүдэн шүүх гэдэг юм уу, бусад байдлаар эрхийн хязгаарлалт хийгдэх байдлаар хүний эрхийн тухай хязгаарлаж ойлгож болохгүй байх. Хүний эрх бол өөрөө маш өргөн хүрээтэй ойлголт.

Би саяхан 1960 оны Үндсэн хуулийн хүний эрхтэй холбоотой бүлгийг уншиж байлаа. Тэр 1960 оны Үндсэн хуулийн хүний эрхтэй холбоотой бүлэг дээр хүний эрх, түүний хэрэгжих баталгааг тухайн Үндсэн хуульдаа маш тодорхой зааж өгсөн байх жишээтэй. Жишээлэхэд, сурч боловсрох эрхтэй. Их дээд сургуульд сурч боловсрох эрхийг дараах байдлаар төр хангана гээд бүр тодорхой детальчилж бичсэн байдаг юм байна лээ.

Тэгээд би дараагийн асуултаар юу асуух гэж байна гэхээр хүний эрх бол заавал бусдын эрхээр хязгаарлагдана.

Тэгэхээр хүний эрх бусдын эрхээр хязгаарлагдаж байгаа тохиолдолд хүний эрх хамгаалагч гэдгээрээ бусдын эрхэнд халдах бид орон зайг үүсгэх вий дээ.

Сүүлийн жилүүдэд манай Нэгдсэн Үндэстний Байгууллагаас манай улс дахь хүний эрх.../минут дуусав/

С.Бямбацогт: Ц.Мөнхцэцэг гишүүн хариулъя.

Ц.Мөнхцэцэг: Тэгэхээр өргөн барьсан төсөл дээр “хүний эрх хамгаалагч” гэдгийг “ганцаараа, эсвэл бусадтай эвлэлдэн нэгдэж хүний эрх хамгаалах үйл ажиллагаа явуулж байгаа, түүнд оролцож байгаа хүнийг” гэж зааж өгсөн байгаа.

Тэгэхээр энэ бол хэт тийм өргөн хүрээтэй заалт байна гэж Х.Нямбаатар сайд асууж байна. Энэ дээр ажлын хэсэг дээр нэлээн ярьсан. Олон улсын загвар хууль буюу Монгол Улс болон бусад шинээр ардчилалд шилжиж байгаа улс орнуудад энэ хуулийн дагуу ерөнхийдөө олон улсын хүний эрхийн хамгаалах механизмаа бий болго гэдэг зөвлөмжийг бас нэлээд үзэж харсан.

Ер нь өргөн хүрээтэй байж тухайн нөхцөлд хүний эрх хамгаалах юм байна. Жишээлбэл, хэн ч хүний эрх хамгаалагч байж болно. Ажил дээр нь

ажлын байрны бэлгийн дарамт гэдэг юм уу, ямар нэгэн даралт үүссэн. Тэр тохиолдолд тухайн ажлын хэн нэг нь ч байдаг юм уу, нэг ажилтан яг тэр кэйс дээрээ хүний эрх хамгаалагч болоод тэмцэж болно.

Эсвэл хөдөө орон нутгийн тодорхой иргэд, манай малчид гэдэг юм уу газар нутаг, уул уурхайн асуудлаас болоод бэлчээрээ хамгаалж байгаа гээд. Тийм учраас энэ яг хүнээр хамгаалагч гэдэг их тийм нарийн явцуу тодорхойлох боломжгүй гэж ажлын хэсэг дээр бид ярьж ингэж оруулсан байгаа.

Тэгээд хоёрдугаар асуултын хувьд яах аргагүй хуулийг ингээд баталсны дараа хүний эрх хамгаалагч нэрээр бусдын эрх чөлөөнд халдах, эсвэл хууль бус гэдэг юм уу, улс төрийн зорилготой, хүчирхийлэлд уриалан дуудсан ийм ажиллагаа явуулах вий гэдэг болгоомжлолыг хүмүүс нэлээн хэлсэн.

Ажлын хэсэг дээр үүнийг нэлээд харж. Яг хүний эрх хамгаалагч гэдгийг хүний эрхийн нэрээр тодорхой зорилгоор гэдэг юм уу, хүчирхийлэл бүхий үйл ажиллагаа явуулдаг хүнээс ялгана. Өөрөөр хэлбэл тухайн жагсаал цуглаан, эсвэл тухайн хүний эрхийн төлөө тэмцэлд оролцогч маань тайван арга замаар, хуулийн дагуу хүний эрхийн төлөө тэмцэнэ.

Түүнээс биш экстремист гэдэг юм уу, эсвэл алан хядах зорилгоор, эсвэл улс орны аюулгүй байдал, үндэсний аюулгүй байдалд аюул занал учруулсан. Нэг бол хүчирхийлэлт арга зам уриалсан тохиолдолд энэ хууль тэр хүнд үйлчлэхгүй. Өөрөөр хэлбэл энэ тохиолдолд тухайн этгээд хүний эрх, хамгаалагч биш гэж тооцогдоно.

Тийм учраас хуулийн гол хамгаалалт бол хүний эрхийн төлөө зүтгэгчийг хүний эрхийн нэрээр өөр зорилгоор үйл ажиллагаа явуулдаг этгээдүүдээс ялгаж байгаа юм. Энэ дээр гол ач холбогдол оршиж байгаа.

С.Бямбацогт: Ажлын хэсгийн гишүүн. Ж.Сүхбаатар гишүүн нэмж хариулъя.

Ж.Сүхбаатар: Х.Нямбаатар гишүүний асуусан хоёр асуулт бол би ч гэсэн анх энэ хуулийн төслийг хэлэлцэхэд асууж байсан, эргэлзэж байсан ийм асуудал л даа.

Тэгээд сүүлд нь хууль санаачлагчтай яриад бас ойлгохыг хичээсэн. Тэгээд нэгдүгээрт бол ийм л юм билээ. Шүгэл үлээгч бүхэн хүний эрх хамгаалагч биш. Хүний эрх хамгаалж байгаа хүмүүсийн дийлэнх нь үндсэндээ шүгэл үлээж байгаа юм.

Тэгэхээр яг тэр шүгэл үлээгчийн хууль орж ирэх ёстой. Бараг үндсэндээ Авлигатай тэмцэх газар бэлэн болгоод явж байгаа гэж ойлгож байгаа. Их Хурлын дарга дээр яригддаг байсан. Одоо ямар шатанд байгааг мэдэхгүй байна.

Миний бас нөгөө нэг болгоомжлол юу байсан бэ гэхээр энэ хүний эрх хамгаалагч нэрийн доор дурын хүн янз бүрийн улс төрийн шинжтэй ч гэдэг юм уу акцууд явуулаад хүмүүсийг сэтгэл зүйд нөлөөлөл явуулаад байх юм гэж.

Тэгэхээр Хүний эрхийн Үндэсний Комиссын дэргэд ажиллаж байгаа энэ хороо өөрөө “хүний эрх хамгаалагч” гэж хэн бэ гэдгээ хуулийнхаа хүрээнд ойлгоод, тодорхойлоод, тэдний эрх зөрчигдөх юм бол тэр гомдол, хүсэлтийг нь хүлээж авах явцдаа түүнийгээ тодорхойлоод явчих юм билээ гэж. Энэ бол ингээд бас хэвшиж тогтохдоо. Түүнээс биш яг хуулийг уншихад бас л яах аргагүй тийм юм харагдаад байгаа.

Тэр Шүгэл үлээгчийн хууль орж ирмээр юм билээ. Энэ бол нийгэмд хууль бус болж байгаа үйлдэл, явдлуудыг өөртөө болон ямар нэгэн байдлаар олж мэдсэн этгээд тэр асуудлыг шүгэлддэг.

Энэ “хүний эрх хамгаалагч” гэдэг бол яг хүний эрхийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаагаа явуулж байгаа. Нөгөөдөх нь буруу бүхэн, ямар нэгэн хууль бус нийгэмд болж байгаа тэр бусармаг үйлдлүүдийг олж мэдсэн мэдээллийнхээ хүрээнд нийтэд хүргэж байгаа ийм хүн байгаад байгаа.

Тэгэхээр зарим тохиолдолд энэ давхцаж байгаа боловч “хүний эрх хамгаалагч” гэдэг нь “шүгэл үлээгч”-ээсээ өөр юм билээ.

Тэгээд тэр хууль санаачилж хэлсэн нэг үгийг би хэлмээр байна. Энэ хүний эрх хамгаална гэдэг нь нэг байгууллага, нэг этгээдийн хийдэг ажил биш. Олон талтай, олон ийм нүх сүв байна. Онгорхой. Хүний эрхийг хамгаалах механизм сул дорой байгаа.

Тэгэхээр энэ олон нүх сүвийг.../минут дуусав/

С.Бямбацогт: Гишүүд ажлын хэсгээс асуулт асууж, хариулт авч дууслаа.

3 сарын 25-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаан дээр Улсын Их Хурлын даргаас гүйцээн боловсруулах чиглэл өгсний дагуу болон ажлын хэсгээс боловсруулсан зарчмын зөрүүтэй саналуудаар санал хураалт явуулна.

Санал хураалтыг түрүүн бид Байнгын хорооны хуралдаан дээр гар өргөж хурааа гээд дэгээ тохирчихсон. Тийм үү. М.Үнэнбат аа. Одоо гараа өргөж хураана. Сошиалаар Б.Дэлгэрсайхан гишүүн орж байна. Ц.Сэргэлэн гишүүн орж байна. Санал хураалтыг гар өргөж хураана гэдгийг манай гишүүд анхаарсан байх.

Ингээд зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг Та бүхэнд уншиж танилцуулъя.

Нэг. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42.2.1-д заасны дагуу хураалгах санал.

1.Төслийн 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалтын “арга” гэсний дараа “хэрэглэж” гэж нэмж, мөн зүйлийн 7.1.2 дахь заалтын “алдар хүнд, нэр төрийг” гэснийг “үйл ажиллагааг” гэж, 7.1.3 заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“7.1.3.хүний эрх, эрх чөлөө, бусдын нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаах”.

Санал гаргасан Ажлын хэсэг. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт.

11 гишүүн дэмжлээ.

2.Төслийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“13.1.Энэ хуулийг 2021 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.”

Санал гаргасан Ажлын хэсэг. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

9 гишүүн дэмжиж, олонхын санал авч дэмжигдлээ. Цахимаар 3 гишүүн байна. Давхар манай ажлын алба тоолж байгаа биз.

Дараагийн санал хураалт.

Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42.2.3-т заасны дагуу хураалгах санал.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“Хүний эрх хамгаалагч нь хүчирхийллийн арга хэрэглэж, тайван бус аргаар үйл ажиллагаа явуулсан, явуулахыг уриалсан, хүний эрх хамгаалагчийн үйл ажиллагааг хувийн ашиг сонирхолд ашигласан, хүний эрх, эрх чөлөөг зөрчиж, бусдын нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.”

Санал гаргасан Ажлын хэсэг. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

Ингээд 9 гишүүн дэмжиж байна. 10 гишүүн.

Санал хураалтыг явуулж дууслаа. Хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцэж бэлтгэсэн талаарх Байнгын хорооны танилцуулгыг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэг. Ажлын хэсгийн ахлагч танилцуулна.